

СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН 2021.03.19 №11 (11)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ОРЧИН ЦАГИЙН ЗЭВСЭГ ХҮЧИН ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЭЭ

"Эрхэм генерал, офицер, ахлагч, гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан, албан хаагчид аа, Энхийг сахиулагчид аа, Үе үеийн Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, бэлтгэлд болон чөлөөнд байгаа ахмад дайчин, цэргийн бэлтгэл үүрэгтэн, Монгол Улсын нийт иргэд ээ!

Та бүхэнд орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойн гал халуун мэндийг дэвшүүлье!

Хүн төрөлхтний түүхэнд тод мөрөө үлдээсэн нүүдэлчдийн төрт улсууд, Хүннү гүрнээс улбаалаад Эзэн Богд Чингис хааны туг дор ертөнц дахинаа алдраа дуурьсгаж явсан талын дайчдын хойчис орчин цагийн цэргийн зохион байгуулалтад орсноос хойш өнөөдөр 100 жилтэй золгож байна.

Монгол үндэстэн бүрэлдэн тогтсон найман мянган жилийн туршид хөрш улсуудын түүхчид "эр бүр нь аян дайнд оролцох ёстой. Нум татаж чадах насанд хүрсэн эр бүр хуягт морьт цэрэг болдог" гэж онцлон тэмдэглэж ирсэн байдаг.

Тийм ээ, бид бол энэ дэлхий дээр хуруу дарам цөөхөн байдаг цэргийн, дайчин үндэстний нэг. Цэргийн урлагийн түүхэнд ул мөрөө үлдээсэн Их Монгол Улсын аугаа дайчин цэргүүдийн залгамж хойч билээ.

Шинээр эмхлэн байгуулагдсан Монгол Ардын Журамт цэрэг 1921 оны 3 дугаар сарын 18-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын удирдлага дор эх нутгаа харийнхнаас чөлөөлөх зэвсэгт тэмцлийг эхлүүлснээр орчин үеийн Зэвсэгт хүчин үүсэн бий болсон. Энэ цагаас хойш Монголын Зэвсэгт хүчин 1939 онд Халхын голын, 1945 онд Чөлөөлөх дайнд оролцон бахдам ялалтуудаар түүхээ зузаатгасан. Энхийн цагт хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэл, дэд бүтэц, барилгын талбарт гар бие оролцон ажиллаж үнэлж баршгүй хувь нэмэр оруулан ард түмнийхээ бахархал болсон билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувиар миний бие энэ баярт өдрийг тохиолдуулан Монголын Зэвсэгт хүчний түүх, Зэвсэгт хүчний гадаад харилцаа, хамтын ажиллагаа, эх орныхоо хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг хамгаалахад оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүрэг, тусгаар тогтнолын төлөө алтан амиа зориулсан баатрууд, ахмад дайчдаараа бахархан омогшиж, үйл хэргийг нь мөнхжүүлэхийг нийт ард түмэн, ялангуяа залуу үеийнхэн, хүүхэд, багачууддаа уриалж байна. Та нар бол энэ улсын ирээдүй, залгамж халаа. Тийм учраас түүхээ мэдэж,



түүнийг бахархалтайгаар, нэр төртэйгөөр үргэлжлүүлэх үүрэг хариуцлагаа эртнээс ухамсарлаж, дээдэлж явах учиртай. Өнөөдөр Монгол Улсын Зэвсэгт хүчин эх орныхоо халдашгүй дархан байдлыг сахин хамгаалахын зэрэгцээ энхийг дэмжих болон олон улсын цэргийн бусад ажиллагаанд амжилттай

оролцон улс орныхоо нэр хүндийг олон улсын тавцанд өндөрт өргөж явна. Түүнчлэн улс орны стратегийн бүтээн байгуулалтын ажилд мэргэжлийн болон техникийн өндөр бэлтгэлжилт, зохион байгуулалттайгаар оролцсоноороо монголчууд бие даан том бүтээн байгуулалтыг

өрнүүлж, гүйцэтгэж чадахыг ард түмэндээ нотлон харууллаа. Та бүхэнд орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн мэндийг дахин хүргэж, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Мөнх тэнгэрийн хүчин дор Бүх Цэргийн Их Хар Сүлд амгалан цэнгэж, аюул занал түүн дор сөхрөн мөхөстөх болтугай.

Монгол Улс, монгол цэрэг мөнхөд оршиг!

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧ Х.БАТТУЛГА

ТӨРИЙН ДАЛБААГ МАНДУУЛЖ, ЁСЛОЛЫН БУУДЛАГА ХИЙВ



Зэвсэгт хүчний Жанжин штабаас орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан олон бүтээлч ажил, арга хэмжээг зохион байгуулаад байна. 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос цар тахлын халдварын тархалт нэмэгдэж буйтай

холбогдуулан Улаанбаатар хотод гамшгийн үеийн хугавдугаар түвшинд 14 хоногийн хугацаатай шилжүүлсэн. Үүнтэй холбогдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабаас зохион байгуулахаар төлөвлөж байсан орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын хурал, нэгдсэн тооллого, цэцэг өргөх ёслол, энхийг сахиулагчдад төрийн одон, медаль гардуулах

ёслол зэрэг баярын арга хэмжээнүүдийг Засгийн газрын шийдвэрийн дагуу 3 дугаар сарын 28-ны өдрөөс хойших хугацаанд зохион байгуулахаар болсон юм. Гэсэн хэдий ч түүхт их ойн өдөр буюу "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд Монгол Улсын Төрийн далбааг мандуулж, ёслолын буудлага хийлээ.

ОЛОН УЛСЫН ЦЭРГИЙН НААДМЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ ЯВАГДЛАА

ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас "Олон улсын цэргийн наадам"-ыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд 2021 онд явагдах тэмцээний талаар зохион байгуулагч, оролцогч, ажиглагч орнуудын саналыг сонсож, байр сууриа нэгтгэлээ. Олон улсын цэргийн наадмын хоёрдугаар шатны төлөвлөлтийн хуралд Монгол Улсын талаас ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг нарын албаны хүмүүс оролцож Монгол Улсын Зэвсэгт хүчний оролцохоор төлөвлөсөн уралдаан, тэмцээнүүдийн талаар тодотгосон юм.

Тухайлбал, цахим хурлын үеэр бригадын генерал С.Дашзэвэг Монгол Улсын Зэвсэгт хүчин "Аравт" морин цэргийн олон улсын уралдааныг 2019 онд анхлан зохион байгуулж, гарааг нь тавьсан орны хувьд 2021 онд уламжлал болгон зохион байгуулж, "Цэргийн ралли" уралдааныг хамтран явуулахад бэлэн гэдгээ илэрхийлэв. Мөн жил бүр өндөр амжилт тогтмол үзүүлж ирсэн "Танкийн биатлон", "Хээрийн гал тогоо", "Мэргэн буудагчийн зааг", "Инженерийн томьёолол" тэмцээнүүдэд оролцож, бусад нэр бүхий төрөлд нь ажиглагчаар оролцох боломжтой гэдгээ онцолсон юм.



ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
-5°C	-17°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
37°C	26°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
18°C	7°C

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,388.0	3,456.0
CNY	437.10	441.40
RUB	37.96	39.72
JPY	25.89	26.42
KRW	2.48	2.60

КОВИД-19 МЭДЭЭ	
ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	158
НИЙТ БҮРТГЭГДСЭН	4498
ЭДГЭРСЭН	3212
НАС БАРСАН	9

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ	
ШИНЭЭР НЭМЭГДСЭН	11
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	248
ЭДГЭРСЭН	959

2021.03.19
/БААСАН ГАРАГ/
ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ХОЁР ХАР УЛААН БАР ӨДӨР

Үс засуулвал:
Өнгө зүс сайжирна
Наран ургах, шингэх:
06.57-19.03
Барилдлага: Шид Шүтэн барилдлага:
Хурьцахуй
Суудал: Мод

Аргын тооллын 3 сарын 19, Сугар гараг, Билгийн тооллын 6, Чөлөөт эх одтой, улаан бар өдөр. Өдрийн наран 6 цаг 57 минутад мандан, 19 цаг 03 минутад жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, бэрийн үйлд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өнгө зүс сайжирна.

Д.Ганзориг: МӨРДЭСТЭЙ БҮХЭН БАХАРХАЛ БОЛСОН АЛБАА ЭРХЭМЛЭЖ ЯВААРАЙ



Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг 3 дугаар сарын 17-ны өдөр төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын даргалах албан тушаалын ахлагчийн бүрэлдэхүүнтэй цахимаар хуралдлаа.

Хошууч генерал Д.Ганзориг эхлээд цахим хуралд оролцогчдод орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэнд өргөн дэвшүүлээд, Зэвсэгт хүчний гол цөм болсон ахлагч нарын үүрэг гүйцэтгэлт, хөгжил, харилцаа, хандлага, сэтгэлгээ, сахилга, хариуцлага, ёс зүй зэрэг хэд хэдэн сэдвээр ярилаа.

“Хэдийгээр өнөөдөр баярын өдөр ч гэсэн бидэнд ярилцах асуудал байна. Зэвсэгт хүчин нийгмийн толь, үлгэрлэгч байх ёстой салбар. Нэг нь л хазгай

гишгэхэд салбараараа цахим сүлжээгээр шүүлгэж байна. Зэвсэгт хүчний нэр хүнд хугацаат цэргийн алба хаагчаасаа эхлээд ЗХЖШ-ын дарга хүртлээ бүх хүнд хамаатай. Зэвсэгт хүчний олонхийг бүрдүүлж байгаа ахлагчийн албаныхан та бүхэн үүнд илүү их анхаарал хандуулж, сахилга, хариуцлага нэмэгдүүлэх шаардлагатай байна. Харилцаа, хандлага, сэтгэлгээгээ өөрчил. Хүний өмнөөс ажил хийж байгаа мэт ялархаж, даалгасан ажлыг аргацаасан байдлаар урсгалаараа явж таарахгүй шүү. Өөрсдийгөө эх орныхоо бахархал болсон салбарт алба хааж байгаа үнэт зүйлээ сайн ойлгох хэрэгтэй” гээд өөртөө тавих шалгуураа өндөрсгөж, сурч боловсрох, бие бялдар, эрүүл мэнддээ онцгой анхаарч байхыг сануулав. Ялангуяа, 2021 онд

ахлагчийн бүрэлдэхүүний эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд ахлагч бүрийн оролцоо чухал. Эрүүл бөгөөд бие бялдрын бэлтгэлжилтэй хүн л үүргээ сайн гүйцэтгэнэ. Энэ ухагдахууныг сайтар ойлгож, ажил, амьдралаа 7 хоног бүрээр нь төлөвлөн, хэрэгжүүлж сурах хэрэгтэй. Яагаад хувь хүний хөгжил яриад байна гэжээ хөгжил яриад байна гэжээ хөгжил хөгжлөөс Зэвсэгт хүчний хөгжил хамааралтай юм гээд ахлагчийн бүрэлдэхүүнийг албандаа эзэн нь болж, өөрийгөө хөгжүүлж, сахилга хариуцлага, ёс зүйн алдаа дутагдал гаргахгүйн төлөө ажиллахыг даалгалаа. Цахим уулзалтад ЗХЖШ-ын даргатай хамт ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр оролцсон юм.

ТҮҮХТ ОЙГОО ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Дорнод аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд Монгол дайчдын хөшөөнд цэцэг өргөх ёслолын ажиллагааг өчигдөр зохион байгууллаа. Тус ёслолын ажиллагаанд Дорнод аймгийн удирдлагууд, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлага, ахмад дайчид болон бусад албаны төлөөлөгчид оролцов.

Түүнчлэн түүхт ойн хүрээнд зохион байгуулсан “Монголын

Зэвсэгт хүчин-100” сэдэвт гар зургийн уралдаанд 11 сургуулиас 75 бүтээл ирсэн бөгөөд Хан-Уул цогцолбор сургуулийн 126 ангийн сурагч А.Төгөлдөр, “Flower” сургуулийн 12а ангийн сурагч О.Мөнх-Ундрал, 12 дугаар сургуулийн 116 ангийн сурагч Х.Хүслэн нарын бүтээл эхний 3 байрыг эзэлж, тусгай байрт Хан-Уул цогцолбор сургуулийн 11а ангийн сурагч Д.Мөнх-Эрдэнэ, 12 дугаар сургуулийн сурагч Т.Батбилэг нарын бүтээл шалгарлаа.

Мөн түүхт ойн хүрээнд Монгол

Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын дархлаа, үнэт зүйлс, орон нутгийн хөгжлийн асуудлыг хүүхэд залуучуудад таниулан ойлгуулах, төлөвшүүлэх, ахмад дайчдын гавъяа зүтгэлийг алдаршуулан мөнжүүлэх зорилгоор Дорнод аймгийн Цэргийн штаб “Аминаас үнэтэй эх орон” гурван үеийн уулзалт ярилцлагын нэвтрүүлгийг бэлтгэн орон нутгийн телевизүүд, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар болон Цэргийн штаб өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна.

НЭГТГЭЛИЙНХЭН АЛБА ХААГЧДАДАА ӨРГӨӨ ЦАГААН ГЭР БЭЛЭГЛЭЛЭЭ



“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн босгон дээр нэгэн үйлсийн аяныг зохион байгууллаа. Нэгтгэлийн

офицеруудын зөвлөлөөс санаачлан өрнүүлсэн энэхүү аяны хүрээнд нэгтгэлийн дэд ахлагч Б.Адилбиш, дэд ахлагч Х.Анхбаяр нарт тус бүр таван ханатай

өргөө цагаан гэр бэлэглэлээ. Үүгээр зогсохгүй тус нэгтгэлд хугацаат цэргийн алба хааж байгаа Төв аймгийн харьяат байлдагч У.Анхбаяр, Э.Жадамба нарын ар гэрт болон Төв аймгийн Зуунмод сумын иргэн З.Уртнасан, Н.Наранцацрал нарт эд материал, хүнсний бүтээгдэхүүний тусламж үзүүллээ.

Энэхүү аяны сэтгэлийн өглөгээндээ очих арга хэмжээнд тус нэгтгэлийн захирагч, хурандаа Т.Лодойдамба, Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Төмөрчөдөр нарын албаны хүмүүс оролцсон юм.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

ЦАХИМ ШУУДАНД

ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙНХЭНД ШАГНАЛЫН ХҮР БУУВ

014 дүгээр анги

“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойгоор эрхэлсэн албандаа үр бүтээлтэй ажиллаж байгаа Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн цэргийн гал тогооны тогооч С.Туул

“Алтангадас” одон хүртсэн бол нэр бүхий 18 алба хаагч салбарын медалиар шагнагдлаа.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн тушаалаар албан тушаалын зэрэглэлийн дагуу ахмад Г.Нэмэхбаярт хошууч, ахлах

дэслэгч О.Мягмарцэрэнд ахмад, дэслэгч Б.Уянга, дэслэгч Ц.Сүхбаяр нарт ахлах дэслэгч, сургагч ахлагч Н.Мянгатад тэргүүн ахлагч цол тус тус олгосныг ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаатар гардуулан өгсөн юм.



2020-2021 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу явагдсан хэргийн гаралт, полигоны дадлагын төгсгөлд “МББ-ны хориглох байлдаанд инженерийн салаагаар хүч нэмэгдүүлсэн МБР-ын ажиллагаа” сэдвээр

байлдааны буудлагатай тактикийн хэргийн сургуулийг амжилттай зохион байгуулав. Сургуулиар инженерийн анги, салбарууд шаардлагатай тохиолдолд мотобуудлагын салбаруудын байлдааны үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх дадлага, чадвар эзэмших

зорилго тавин ажиллалаа. Зэвсэгт хүчний инженерийн цэргийн хувьд анх удаа ротын байлдааны буудлагатай тусгай тактикийн хэргийн сургуулийг зохион байгуулж байгаа нь энэ удаагийн хэргийн гаралтын онцлог байлаа.

Хошууч Д.ХАДХҮҮ

ЦЭРЭГ, СПОРТЫН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ

325 дугаар анги



“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт

хүчний түүхт 100 жилийн ойн баярыг тохиолдуулан

Зэвсэгт хүчний 325 дугаар анги Завхан аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд спортын цогцолбор тэмцээнийг аймгийн Спортын төв ордонд зохион байгуулан эхлүүлээ. Тэмцээнд нийт 12 байгууллагын 350 алба хаагч сагсан болон гар бөмбөг, ширээний теннис, шатар, зуун буудалт даам, усанд сэлэлтийн төрлөөр өрсөлдөж марш тактикийн аварга тасаг, 2021 оны аварга офицер, ахлагч, эмэгтэй цэргийн алба хаагчдыг тус тус шалгаруулах юм.

ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ, ХҮМҮҮЖЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ АЖЛУУД ЯВАГДЛАА

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан “Монгол Улсын Зэвсэгт хүчин-100” сэдэвт гар зургийн уралдаанд Сэлэнгэ аймгийн оюутан,

сурагчид амжилттай оролцлоо. Мөн Монгол цэргийн нэгдсэн холбоо, “Отгонтэнгэр” их сургуулиас хамтран зохион байгуулсан “Эрхийн дээд Монгол эр хүн” сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд Сэлэнгэ

аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн сурагч Б.Эрхэм-Эрдэнэ 210 хүүхдээс тэргүүлээ.

ГАР ЗУРГИЙН УРАЛДААНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан “Монгол Улсын Зэвсэгт хүчин-100”

сэдэвт гар зургийн уралдаанд Өвөрхангай аймгийн оюутан, сурагчид амжилттай оролцож Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн төрөлд

тус аймгийн Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 4в ангийн сурагч С.Мөнхсаруул, их, дээд сургууль, коллежийн оюутны ангилалд Хайрхандулаан сумын оюутан Д.Чойням нар шагналт тусгай байрт шалгарлаа.

“Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ноос зохион байгуулсан “Эрхийн дээд Монгол эр хүн” сэдэвт эсээ бичлэгийн цахим уралдаанд тус аймгийн нийт 11 сумын 15 сургуулийн 12 дугаар ангийн 186 сурагчид оролцсоноос Арвайхээр сумын “Мэргэд” лаборатори сургуулийн 12в ангийн сурагч Э.Энхчимэг шагналт тусгай байрт шалгарч, “Отгонтэнгэр” их сургуульд 1 /нэг/ жил үнэ төлбөргүй суралцах эрхээр шагнууллаа.

Дэд хурандаа Ч.АДЬЯА



СОЁМБО СОНИН
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

Эхийг “Соёмбо” сонин редакцал бэлтгэв.

*Зар, рекламь хямд нийтэлнэ.
*Зар, рекламь үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029